



**БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ**

ТЭГШ ХАМРАН СУРГАЛТЫН ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

*СӨЕББХЗГ-ын
дарга Т.Ням-Очир*



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

Тэгш хамран сургалтын өнөөгийн байдал

Насны ангилал	Боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй /ESIS/	Боловсролд хамрагдалт	Тусгай цэцэрлэг, сургуульд /нийт 6 сургууль, 3 цэцэрлэг/	
2-5 нас	1065	/62.2%	403	37.8%
6-17 нас	6208	/72.9%	1683	27.1%
Бүгд	7273			

2019-2020

2020-2021

СӨБ:1076

СӨБ:1156

ЕБС: 6053

ЕБС: 5986

Их, дээд сургуульд: 400

- хувьсах зардал 3 дахин
- оюутанд буцалтгүй тусламж

Багшийн нэмэгдэл

Тусгай цэцэрлэг,
сургууль:+30%

Ердийн цэцэрлэг,
сургууль:+10%

Анхаарах асуудал:

- * Статистик мэдээ үнэн зөв болгох
- * Боловсролын үйлчилгээнд эрт хамруулах
- * ХБХ-ийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс 2016 ЗГТ №200

**Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл, Дэмжлэгийн баг

**“АЛСЫН ХАРАА-2050”
МОНГОЛ УЛСЫН УРТ
ХУГАЦААНЫ
ХӨГЖЛИЙН БОДЛОГО:**

**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН
2020-2024 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРТ**

- **Зорилт 2.1.**Хүн бүрд чанартай боловсрол эзэмших **тэгш боломж бүрдүүлж**, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ.
- **Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн**
- **I үе шат (2021-2030):** Хүн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцооны шинэчлэлийн үе.

- **2.3.**Хүн бүрд чанартай боловсрол эзэмших **тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог** бэхжүүлнэ.
- **2.3.9.**Суралцагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх, **тусгай хэрэгцээт хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх**
- **2.3.9.3.**тусгай хэрэгцээт сургууль, цэцэрлэгийн барилгыг шинэчилж, өргөтгөх

Тулгамдаж буй асуудал, бэрхшээл

- Тэгш хамран сургах сургалтын хүртээмжтэй орчин
- Ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах багшийн арга зүй, хандлага
- Багшийн ажлын үнэлэмж
- Хандлага:
 - эцэг эх, асран хамгаалагч
 - ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн талаарх бусад хүүхдийн ойлголт
 - удирдлага
- салбар дундын хамтын ажиллагаа
- дэд бүтэц, нийгмийн орчин, нөхцөл
- Танхимын сургалтад хамрагдах боломжгүй хүүхдийг боловсролд хамруулах



Асуудал, шийдэл

Хэрэгжүүлж буй арга хэмжээ

- ХБ хүүхдийг цэцэрлэг, ЕБС-д тэгш хамран сургах журам, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр /засан сайжруулах/ 2019- А/292, 2020-А/177
- Багш бэлтгэх, давтан бэлтгэх /МУБИС 55+70+100 багш, гадаадад 10 багш, мэргэжил дээшлүүлэх сургалт/
- ХБ хүүхэдтэй ажиллаж буй багшид нэмэгдэл олгох ЗГТ /2020,№208/, аргачлал-2020-А/296
- Хүүхэд хөгжлийн танхим байгуулах /загвар танхим/, хуульд тусгах
- Хүүхэд хөгжлийн танхимын үйл ажиллагааны чиглэл 2020-А/249
- Бүх шатны боловсролын байгууллагад орчин бүрдүүлэх журам 2020-А/184
- Эцэг эх, асран хамгаалагчдад зөвлөгөө, мэдээлэл

Тулгамдаж буй асуудал, бэрхшээл

- Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг тэгш хамран сургах сургалтын хүртээмжтэй орчин
- Ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах багшийн арга зүй, хандлага
- багшийн ажлын үнэлэмж
- Хандлага:
 - эцэг эх, асран хамгаалагч
 - ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн талаарх бусад хүүхдийн ойлголт
 - удирдлагын
- салбар дундын хамтын ажиллагаа
- дэд бүтэц, нийгмийн орчин, нөхцөл
- Танхимын сургалтад хамрагдах боломжгүй хүүхдийг боловсролд хамруулах



Асуудал, шийдэл

Хэрэгжүүлж буй арга хэмжээ

- Тэгш хамран сургалтын орчин бүрдүүлэхэд нутгийн захиргааны байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх
- Багшид арга зүйн дэмжлэг үзүүлэх
- Дэмжлэгийн багийг чадавхжуулах
- Статистик мэдээ, мэдээллийг оновчтой болгох
- Брайл сурах бичиг, сургалтын тохирох хэрэглэгдэхүүнээр хангах /технологи ашиглах/
- Эцэг эх, асран хамгаалагчдад зөвлөгөө, мэдээлэл
- Ковидын үед сургалтыг дэмижх, хоцрогдол арилгахад чиглэсэн арга хэмжээ /теле, цахим, интерактив хичээл, зөвлөгөө, зөвлөмж, ДАД, ном хэр-багц/



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 12 дугаар сарын 23-ны
өдөр

Улаанбаатар хот

Дугаар 235

ТЭГШ ХАМРАН СУРГАХ БОЛОВСРОЛЫН ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхий тухай хуулийн 14.1.3, 14.3.1, 14.3.2, 15.10, 16.2, 16.4-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын суралцах эрхийг тэгш хангах чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэнд даалгасугай:

1.1. хүүхдийг хөгжлийн бэрхшээлийн онцлогоос үл хамааран цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд тэгш хамруулах, эрүүл мэндийн шалтгаанаар танхимын сургалтад хамрагдах боломжгүй хүүхдэд тохирсон боловсролын хувилбарт болон явуулын багшийн үйлчилгээг бий болгох талаар холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулах;

хяналтын т: олгох, багш, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийг зөвлөгөө, мэдээлэл, арга зүйгээр хангах хэрэгжилтийг ажлыг чадавхжуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх.

2. Сургалтын цахим технологийг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид хүртээмжтэй хэлбэрээр хөгжүүлэх, цахим контент боловсруулан сургалтад нэвтрүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн, Харилцаа, холбоо, мэдээллийн технологийн газар (Б.Болор-Эрдэнэ)-т даалгасугай.

3. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай ажиллаж байгаа цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны ажлын онцлог, мэргэжлийн шаардлагатай уялдуулан цалингийн сүлжээний ангилал, шатлал, нэмэгдлийг тусгайлан тогтоох боломжийг судалж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяад даалгасугай.

4. Бүх шатны сургалтын байгууллагын барилга байгууламж, нийтийн эзэмшлийн талбай, ариун цэврийн өрөө, анги танхимыг хөгжлийн бэрхшээлтэй суралцагч ашиглах боломжтой стандарттай байхаар тоноглож, тохижуулах цогц арга хэмжээг 2021-2023 онд авч хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх зайлшгүй шаардлагатай тохирох хэрэгтэгдэхүүний зардлыг төсвийн ерөнхийлөн захиралчийн жил бүрийн батлагдсан төсвийн багцдаа багтаан шийдвэрлэж байхыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

5. Бүх шатны сургалтын байгууллагын шинээр баригдах хичээлийн болон дотуур байрны барилгын зураг төслийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй загвараар боловсруулах, барих ажилд хяналт тавьж ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (Т.Гантулга)-т тус тус даалгасугай.

6. Бүх шатны сургалтын байгууллагын орчинд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангасан зохих стандартад нийцүүлсэн зам, талбайтай болгох арга хэмжээг 2021-2023 онд авч хэрэгжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

7. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхэд хүүхдээ боловсролын үйлчилгээнд хамруулахад нь бүх талын дэмжлэг үзүүлж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад уриалсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Боловсрол, шинжлэх ухааны сайд

Л.ЦЭДЭВСҮРЭН

Асуудал, шийдэл

ЗГТ /2020 №235/

- ХБХ-ийг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд тэгш хамруулах, хувилбарт болон явуулын багшийн үйлчилгээг бий болгох,
- их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд хөгжлийн бэрхшээлтэй суралцагч элсүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй оюутанд үйлчлэх ажилтан ажиллуулах
- Гадаад улс оронд оюутан сургах,
- Бүх шатны сургалтын байгууллагын барилга байгууламж, нийтийн эзэмшлийн талбай, ариун цэврийн өрөө, анги танхимыг хөгжлийн бэрхшээлтэй суралцагч ашиглах боломжтой стандартад нийцүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай ажиллаж байгаа цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны ажлын онцлог, мэргэжлийн шаардлагатай уялдуулан цалингийн сүлжээний ангилал, шатлал, нэмэгдлийг тусгайлан тогтоох
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхэд хүүхдээ боловсролын үйлчилгээнд хамруулахад нь бүх талын дэмжлэг үзүүлж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад уриалсугай.

Монгол улсын Боловсролын багц хуулийн төсөлд

- бүх шатны боловсрол, сургалтын байгууллагад ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг хамруулах хүртээмжтэй орчин, нөхцөл бүрдүүлэх
- бүх шатны төр, захиргааны байгууллага, түүний удирдлагын чиг үүрэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол эзэмшүүлэх асуудлыг хамааруулах
- багш нар ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах арга зүй эзэмшсэн байх
- эцэг эхийн үүрэг, оролцоог хангах

- суралцагчийн бусдыг ялгаварлан гадуурхахгүй байх
- сургалтын арга хэлбэр /танхимын, зайн, холимог/
- танхимын сургалтад хамрагдах хугацааг уян хатан болгох /6 настай цэцэрлэгт хамрагдах боломжийг нээх/
- хүүхдийн хөгжлийг дэмжих танхимтай байх
- боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль байх
- их, дээд сургуульд ялгаатай хэрэгцээтэй оюутанд дэмжлэг үзүүлэх орчин бүрдүүлэх

Тэгш хамран сургах

